



ХЭНТИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 57

Хэрлэн сум

Н.Батбаярыг төрийн жинхэнэ  
албаны нөөцөд бүртгэх тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам”-ын 2.1.5, 3.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Наянтайн Батбаяр нь Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтнээр ажиллаж байгаад 2013 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс Төрийн албаны тухай хуулийн 23.4 дэх хэсгийг баримтлан аймгийн Зооноз өвчин судлалын төвийн нягтлан бодогчоор шилжүүлэн томилсон нь тус хуулийн “23.5.Энэ зүйлийн 23.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, мөн зүйлийн 23.4-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийг нөөцөд байгаад тооцно.” гэж заасны дагуу төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэсүгэй.

2. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу Н.Батбаярыг нөөцийн бүртгэлд бүртгэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Ж.Саруултөгс)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА